



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 17-ны өдөр

Дугаар 0/01

Булган

Байгууллагын төрийн албан хаагчдын
цалин шинэчлэн тогтоох ажлын хэсгийн
бүрэлдэхүүнийг байгуулах тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, “Төрийн албаны тухай” хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.2, 57.2.4, 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалтууд, аймгийн Засаг даргын 2021 оны А/439 дүгээр захирамж, Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын нийт төрийн албан хаагчдын 2022 оны цалин шинэчлэн тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Төрийн албан хаагчдын ажилласан жил, төрийн алба хаасан хугацааг харгалзан өнөөдрийн байдлаар Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоол, дүрэм, журмыг баримтлан 2022 оны цалинг шинэчлэн тогтоож, нийт төрийн албан хаагчдыг эргэн мэдээллээр ханган ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (П.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.
3. Төрийн албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан, төрийн албан хаагчийн хувийн хэрэгт нэмэлт баяжилт хийж, санхүүгийн ил тод байдлын зарчмыг баримтлан ажиллахыг Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, салбарын санхүүгийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн (П.Мягмарсүрэн), Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал урамшуулал, байгууллагын дотоод аудит хариуцсан мэргэжилтэн (Б.Батцэцэг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.НАРАНТУЯА

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
01 дугаар сарын 17 -ны өдрийн
А/01 дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ахлагч: П.Мягмарсүрэн- Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, салбарын санхүүгийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд:
- Д.Нарантуяа-Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
 - Ө.Баасансүрэн- Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн
 - Б.Гантулга –Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
 - Б.Батцэцэг- Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал урамшуулал, байгууллагын дотоод аудит хариуцсан мэргэжилтэн